

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
 5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....
-

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ЕРЛАН ТАНАА

2023.02.10 № 45
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 10 жилд нэг удаа зохион байгуулагдах хөдөө аж ахуйн тооллого, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого болон өрхөд суурилсан нийгэм, эдийн засаг, ажиллах хүч, ардчилсан засаглал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн зэрэг томоохон судалгаануудыг графикт хугацаанд нь мэдээллийг цуглуулж нэгтгэн хүргүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,909,522.00</u>	<u>350,000.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,909,522.00	350,000.00
354	Хангамжийн материал	1,909,522.00	350,000.00
35410	Бичиг хэргийн материал	-	-
35420	Аж ахуйн материал	1,909,522.00	350,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,860,048.28</u>	<u>49,155,132.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,860,048.28	49,155,132.29
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	24,860,048.28	49,155,132.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	-
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,000,000.00	9,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,000,000.00)	(9,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,919,684.75	98,619,673.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,264,061.23)	(53,395,426.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,789,200.00	15,479,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,584,775.24)	(11,548,315.36)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(450,000.00)	(450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>26,769,570.28</u>	<u>49,505,132.29</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>26,769,570.28</u>	<u>49,505,132.29</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	26,769,570.28	49,505,132.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	26,769,570.28	49,505,132.29
512	Хуримтлагдсан үр дүн	26,769,570.28	49,505,132.29
51210	Өмнөх үеийн үр дүн	26,769,570.28	26,769,570.28
51220	Тайлант үеийн үр дүн	-	22,735,562.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>26,769,570.28</u>	<u>49,505,132.29</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	225,629,099.00	365,611,484.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,876,786.00	34,391,962.67
120	Нийтлэг татварын бус орлого	10,876,786.00	34,391,962.67
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,876,786.00	34,391,962.67
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,876,786.00	34,391,962.67
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	214,752,313.00	331,219,522.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	106,546,300.00	108,694,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	106,546,300.00	108,694,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,206,013.00	222,525,522.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,898,000.00	13,461,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,367,433.00	209,044,522.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,940,580.00	20,000.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	224,109,265.24	342,875,922.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,109,265.24	342,875,922.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,818,065.24	342,462,532.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,599,496.00	153,509,922.00
210101	Үндсэн цалин	85,526,896.00	120,628,822.00
210102	Нэмэгдэл	23,922,800.00	23,731,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,579,200.00
210104	Урамшуулал	4,570,600.00	4,570,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,120,775.00	17,990,500.00

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	11,501,375.00	14,235,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	904,800.00	938,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	723,900.00	751,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181,000.00	187,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,809,700.00	1,877,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,281,260.00	28,630,232.00
210401	Бичиг хэрэг	945,100.00	198,900.00
210402	Тээвэр, шатахуун	16,171,160.00	23,315,010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,759,000.00	2,949,500.00
210404	Ном, хэвлэл	-	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	406,000.00	2,146,822.00
2107	Томилолт, зочны зардал	15,052,000.00	24,168,000.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	15,052,000.00	24,168,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,879,068.00	108,989,057.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,717,416.00	107,172,857.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	10,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,041,252.00	1,695,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,885,466.24	9,174,821.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,141,900.00	237,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,743,566.24	8,937,821.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	291,200.00	413,390.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	291,200.00	72,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	291,200.00	72,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	340,590.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	340,590.00
213304	Хөрөнгийн	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,519,833.76</u>	<u>22,735,562.01</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,519,833.76</u>	<u>22,735,562.01</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>214,752,313.00</u>	<u>331,219,522.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	214,752,313.00	331,219,522.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	106,546,300.00	108,694,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	106,546,300.00	108,694,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,206,013.00	222,525,522.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,898,000.00	13,461,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,367,433.00	209,044,522.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,940,580.00	20,000.00
131106	Төсвийн урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>214,752,313.00</u>	<u>331,219,522.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,752,313.00	331,219,522.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,461,113.00	330,806,132.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,599,496.00	153,509,922.00
210101	Үндсэн цалин	85,526,896.00	120,628,822.00
210102	Нэмэгдэл	23,922,800.00	23,731,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,579,200.00
210104	Урамшуулал	4,570,600.00	4,570,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,120,775.00	17,990,500.00
210201	Тэтгэврийн даатгал	11,501,375.00	14,235,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	904,800.00	938,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	723,900.00	751,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181,000.00	187,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,809,700.00	1,877,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,377,974.00	25,994,841.00
210401	Бичиг хэрэг	473,700.00	198,900.00
210402	Тээвэр, шатахуун	15,739,274.00	22,485,141.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,759,000.00	2,949,500.00

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл		20,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	406,000.00	341,300.00
2107	Томилолт, зочны зардал	15,052,000.00	24,168,000.00
210702	Дотоод албан томилолт	15,052,000.00	24,168,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,168,968.00	108,905,869.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,820,916.00	107,089,669.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,227,652.00	1,695,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,141,900.00	237,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,141,900.00	237,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	291,200.00	413,390.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	291,200.00	72,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	291,200.00	72,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	340,590.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		340,590.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	≡
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	17,390,879.61		(11,550,155.63)	5,840,723.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,390,879.61	-	(11,550,155.63)	5,840,723.98
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайлант үеийн үр дүн			322,559.88	322,559.88
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		-	26,769,570.28	26,769,570.28
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл		-	26,769,570.28	26,769,570.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	26,769,570.28	26,769,570.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			22,735,562.01	22,735,562.01
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	49,505,132.29	49,505,132.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,694,000.00	108,353,410.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,694,000.00	108,353,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,402,800.00	108,280,610.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,878,400.00	93,878,400.00
210101	Үндсэн цалин	60,997,300.00	60,997,300.00
210102	Нэмэгдэл	23,731,300.00	23,731,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,579,200.00
210104	Урамшуулал	4,570,600.00	4,570,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,734,900.00	11,734,900.00
210201	Тэтгэврийн даатгал	7,979,700.00	7,979,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	938,800.00	938,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	751,000.00	751,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	187,800.00	187,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,877,600.00	1,877,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,673,300.00	1,551,110.00
210401	Бичиг хэрэг	198,900.00	198,900.00
210402	Тээвэр, шатахуун	603,600.00	481,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	529,500.00	529,500.00
210404	Ном, хэвлэл		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	341,300.00	341,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	879,200.00	879,200.00

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.00	198,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	56,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	560,800.00	560,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	237,000.00	237,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	237,000.00	237,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	291,200.00	72,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	291,200.00	72,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	291,200.00	72,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108,694,000.00	108,353,410.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,694,000.00	108,353,410.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	108,694,000.00	108,353,410.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5
620003	Үйлчлэх ажилтан		
620004	Гэрээт ажилтан		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5	5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,206,013.00	222,525,522.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108,206,013.00	222,525,522.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,206,013.00	222,525,522.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,115,496.00	59,631,522.00
210101	Үндсэн цалин	28,115,496.00	59,631,522.00

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210102	Нэмэгдэл		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,905,375.00	6,255,600.00
210201	Тэтгэврийн даатгал	2,905,375.00	6,255,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,150,074.00	24,443,731.00
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун	15,021,074.00	22,003,731.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,129,000.00	2,420,000.00
210404	Ном, хэвлэл		20,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,052,000.00	24,168,000.00
210702	Дотоод албан томилолт	15,052,000.00	24,168,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,123,068.00	108,026,669.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,622,916.00	106,891,669.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,152.00	1,135,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,860,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,860,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108,206,013.00	222,525,522.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108,206,013.00	222,525,522.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,898,000.00	13,461,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,367,433.00	209,044,522.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,940,580.00	20,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь албан ёсны статистикийн мэдээний бодит байдлыг сайжруулах, аймгийн эдийн засаг, нийгэм, хүн амын талаарх статистикийн тоо мэдээллээр нутгийн захиргааны байгууллага, иргэд, аж ахуйн нэгжийг хангах, өрхөд суурилсан түүвэр судалгааны хамралтыг сайжруулах чиг үүрэгтэй байгууллага юм.

Аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 онд “Албаны ёсны статистикт төрийн их өгөгдлийг ашиглах, бэлтгэх ажлыг хангах” зорилго дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:тайлант онд албан ёсны статистикийн 56 мэдээ, захиргааны статистикийн 7 мэдээ цуглуулан нэгтгэн боловсруулж, хуваарийн дагуу дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн 10 жилд нэг удаа зохион байгуулагдах хөдөө аж ахуйн тооллого, жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллого болон өрхөд суурилсан нийгэм, эдийн засаг, ажиллах хүч, ардчилсан засаглал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн зэрэг томоохон судалгаануудыг графикт хугацаанд нь мэдээллийг цуглуулж нэгтгэн хүргүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- Статистикийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нийгмийн даатгал, Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ. Тус байгууллагад дотоод аудитын нэгж ажилладаггүй.

ҮСХ-ны Дотоод аудит, эрсдэл удирдлагын газраас эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд цахимаар дотоод хяналт шалгалтыг хийж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, санхүүгийн заавар зөвлөгөө өгч ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Статистикийн хэлтэс нь Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ны А/162 дугаар тушаалаар баталсан Үндэсний статистикийн хорооны хэмжээнд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22.7 сая төгрөгөөр буюу 54.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага			-
Бараа материал	1,909.5	350.0	(1,559.50)
Үндсэн хөрөнгө	24,860.1	49,155.1	24,295.00
Нийт хөрөнгө	26,769.6	49,505.1	22,735.5
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	26,769.6	49,505.1	22,735.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	26,769.6	49,505.1	22,735.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос бараа материалын данс 1.6 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгийн данс 24.3 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо данс 22.7 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна. Оны эхэнд бараа материалын данс 1.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 38.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч 0.2 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй

хүлээн авч, 40.7 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 90.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 33.4 сая төгрөгийн дансны үнэтэй, 0.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг Үндэсний статистикийн хорооноос үнэ төлбөргүй тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хэлтсийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 240.9 сая, нийт зарлагыг 240.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 131.7 зардлыг сая төгрөгөөр бууруулж, 109.2 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотой үндсэн хөрөнгө бэлтгэх, өрөө тасалгаанд их засвар хийхтэй холбоотой зардлуудыг батлаагүй, бусад урсгал зардлуудыг мөн бууруулж баталсантай холбоотой байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 0.5 сая төгрөгөөр бууруулж, 108.7 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 108.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 108.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст 0.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 108.4 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 0.3 төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	108,204.80	108,082.60	-122.20	99.9
2	80215-Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	198.00	198.00	0.00	100.0
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	291.20	72.80	-218.40	25.0
	Дүн	108,694.00	108,353.40	-340.60	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлан онд Статистикийн хэлтэс нь Үндэсний статистикийн хорооноос улсын хэмжээний тооллого болон бусад тооллогын зардалд 209.0 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тооллогын зардалд 13.5 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 0.02 сая төгрөгийн нийтдээ 222.5 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж ажилласан байна.

Зарцуулалтыг үзэхэд: цалин хөлсний зардалд 59.6 сая, хангамж, бараа материалын зардалд 24.4 сая, томилолт, зочны зардалд 24.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 108.0 сая төгрөгийн тус тус зарцуулах эрх авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Статистикийн хэлтэс нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 16 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аймгийн Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 224.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: хангамж бараа материалын зардлаас 0.1 сая төгрөгийг, Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 0.2 сая төгрөгийг тус тус хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил гараагүй байна. /Хэрэгжилтийг хүснэгтээр баримтжуулав./

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад хуулийн дагуу мэдээллээ хугацаанд нь бүрэн оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Статистикийн хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хэлтсийн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ҮСХ-ноос тус хэлтэст 2022 онд Ланд круйзер GX200 маркийн суудлын автомашиныг Статистикийн хэлтэст үнэгүй шилжүүлсэн ба хэлтсийн даргын 2022 оны 2 дугаар сарын 24-ны өдрийн А/06 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж, автомашиныг хүлээн авсан байна. ҮСХ-ноос уг автомашиныг орлого авч данс бүртгэлд тусгах талаар шийдвэрийг одоог хүртэл ирүүлээгүйгээс санхүүгийн тайлан балансад тусгагдаагүй байна. Энэхүү автомашиныг статистик судалгааны мэдээлэл цуглуулах ажилд ашиглагдаж байгаа тул данс бүртгэлд тусгах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/		Зөвлөмж
				Үүнээс		
				Залруулсан	Залруулаагүй	

Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Тоо	Дүн										
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										
